



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 21 өдөр

Дугаар

A/455

Ховд

Газар өмчлөх эрх шилжүүлэх тухай

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалтуудыг үндэслэн Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2005 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 113 дугаар захирамжаар гэр бүлийн хамтын хэрэгцээнд дундаа хамтран газар өмчилсөн иргэний хэлцлийг харгалзан Жаргалант сумын Бугат баг 12-4 тоот, 1224 м2 хэмжээтэй, 3060000 төгрөгийн үнэ бүхий газрыг иргэн Сонингийн Отгонбаярт үнэ төлбөргүйгээр шилжүүлэн өмчлүүлсүгэй.

2. Дээрх иргэний шилжүүлсэн газарт хуулийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга /Э.Дөлбадрал/, Улсын бүртгэлийн хэлтсийн дарга /С.Хоролсүрэн/ нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2005 оны 05 дүгээр сарын 16-ны өдрийн 113 дугаар захирамжийн 3 дугаар хавсралтын 46,47, 48 дахь заалтууд буюу С.Цэвэлмаа, О.Уянга, О.Урангоо нарт холбогдох хэсгийг тус тус хүчингүй болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/455 Ch
02 02022

Аймгийн Засаг даргын 2020 оны
8 дугаар сарын 20-ны өдрийн А/455 дугаар
захирамжийн хавсралт



ГЭР БҮЛИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗАР ӨМЧЛӨХ ЭРХЭЭ НЭГ ГИШҮҮНДЭЭ
ҮНЭ ТӨЛБӨРГҮЙГЭЭР ШИЛЖҮҮЛСЭН ИРГЭНИЙ ЖАГСАЛТ

Овог нэр	Хаяг	Газрын хэмжээ /м2/	Газар өмчилж авсан захирамжийн огноо	Дугаар	Хавсралтанд орсон дугаар
С.Цэвэлмаа О.Уянга О.Урангоо	Бугат баг 12-4 тоот	1224	2005-05-16	113	46,47,48